

# “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр

№ 26/31

Улаанбаатар хот

## Өрийн хэрэгсэл нийтэд санал болгон гаргах тухай

Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйл, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалт, 80 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 16 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2, 9.6.4 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 26/06 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн 2026 оны эх үүсвэрийн төлөвлөгөө” болон Компанийн ТУЗ-ийн 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**


1. Компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөгийн нийт дүн бүхий өрийн хэрэгсэл (цаашид “Өрийн хэрэгсэл”)-ийг нийтэд санал болгон гаргахаар шийдвэрлэсүгэй.
2. Нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн нөхцөлийг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
3. Андеррайтерын үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагаар “Би Ди Сек ҮЦК” ХК-ийг, Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээр “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-ийг тус тус сонгосугай.
4. Аудитын үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагаар “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК ажиллахыг дурдсугай.
5. “Би Ди Сек ҮЦК” ХК-тай “Андеррайтерын үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулах болон үнэт цаасны зах зээлд оролцогч бусад эрх бүхий этгээдтэй хэлцэл хийх, гэрээ байгуулах, шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
6. Өрийн хэрэгслийг нийтэд санал болгож, санхүүжилт татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох баримт бичиг, бусад шаардлагатай гэрээ, хэлцэлд Компанийг төлөөлөн гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
7. Өрийн хэрэгсэл гарган санхүүжилт татан төвлөрүүлэх ажилтай холбогдон гарах аливаа төлбөр, шимтгэл, хураамж, бусад зардлыг холбогдох гэрээ, хууль тогтоомжид заагдсан хугацааны дотор тухай бүр төлөх, Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулан ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
8. Өрийн хэрэгсэл нийтэд гаргахтай холбоотой ажлын үйл явц, үр дүн болон энэхүү тогтоолын хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д тухай бүр танилцуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн  
26/31 тоот тогтоолын Хавсралт



НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ НӨХЦӨЛ

1	Үнэт цаасны нэр	Lend MSME bond
2	Үнэт цаасны төрөл	Энгийн тогтмол хүүтэй нээлттэй өрийн хэрэгсэл (бонд)
3	Арилжаа эрхлэх байгууллага	“Монголын хөрөнгийн бирж” ХК
4	Олон нийтэд санал болгох нийт дүн	20,000,000,000 (хорин тэрбум) төгрөг
5	Бондын нэрлэсэн үнэ	100,000 (нэг зуун мянга) төгрөг
6	Тоо ширхэг	200,000 (хоёр зуун мянга) ширхэг
7	Хүүгийн хувь хэмжээ (жилийн буюу 365 хоног)	18.5 (арван найм аравны тав) хувь
8	Хугацаа	24 (хорин дөрөв) сар
9	Хүү төлөгдөх давтамж	Улирал тутам буюу 8 (найм) удаа
10	Үндсэн төлбөр төлөгдөх хугацаа	Хугацааны эцэст
11	Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт	Компанийн зээлийн эх үүсвэрийн санхүүжилт
12	Санхүүжих чадавхын зэрэглэл	“BBB+” буюу “Тогтвортой”
13	Үндсэн андеррайтер	“Би Ди Сек ҮЦК” ХХК
14	Үнэт цаасны бүртгэл, хадгаламжийн байгууллага	“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК
15	Нийтэд санал болгох хугацаа	2026 оны 09 сард

## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр

№ 26/32

Улаанбаатар хот

### Үнэт цаасны данс нээлгэх, түүнийг захиран зарцуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.5, 9.6.23 дахь заалтууд болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөгийн нийт дүн бүхий “Lend MSME bond” өрийн хэрэгслийг гаргах хүсэлтээ Үндсэн Андеррайтер болох “Би Ди Сек ҮЦК” ХК-аар дамжуулан Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “Хороо”)-нд гаргасан болохыг дурдсугай.
2. “Lend MSME bond” -ыг олон нийтэд санал болгон гаргах зөвшөөрлийг Хорооноос олгосны дараа тус бондыг олон нийтэд санал болгон гаргахад ашиглах үнэт цаасны дансыг Үндсэн Андеррайтер болох “Би Ди Сек ҮЦК” ХК-д шинээр нээлгэх, тус дансыг захиран зарцуулах бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан “Би Ди Сек ҮЦК” ХК-д шинээр үнэт цаасны данс нээлгэх (хүсэлт гаргах, анкет, маягт бөглөх, баримт бичиг гарган өгөх, төлбөр хураамж төлөх, хариу хүлээн авах болон ийнхүү бүртгүүлэхтэй холбоотой бүхий л ажиллагаа хамаарна), түүнийг захиран зарцуулахтай холбоотой бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

УЛААНБААТАР ХОТ  
5039754 ᠎.1118267206

